

ХИЛИЙН ЦЭРГИЙН БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ САХИЛГЫГ БЭХЖҮҮЛЭХ ТАЛААР ЗОХИОЖ БАЙСАН УЛАМЖЛАЛТ АЖЛУУД, ТҮҮНИЙГ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛД ХЭРЭГЛЭХ НЬ

Нийгэмжсэн хүнийг “Бие хүн” хэмээн нэрлэдэг. Бие хүний төлөвшилд олон хүчин зүйлүүд нөлөөлнө. Бие хүнийг нийгэм талаас нь авч үзвэл нийгмийн бүтээгдэхүүн, бодьгал талаас нь авч үзвэл байгалийн бүтээгдэхүүн, Амьтдаас ялгарах гол онцлог нь дохионы II системтэй (хэл, сэтгэхүй)-гээрээ ялгаатай билээ.

Сахилга, хариуцлага гэдэг категори нь тухайн бие хүний хүмүүжил, төлөвшилтэй салшгүй холбоотой. Хүний хүмүүжил, төлөвшилөөс түүний сахилга, хариуцлагыг салган үзэх аргагүй юм. Монголчууд эртнээс нааш тухайн хүний хүмүүжил, сахилга, хариуцлагыг хүмүүжиж төлөвшсөн орчин, нөлөөлөх хүчин зүйлүүдтэй нь уялдуулан тодорхойлжээ. Манай ард түмэн “Эх нь булингартай бол адаг нь булингартай”, “Сахилгагүй хүн ёроолгүй савтай адил”, “Хусавч уг нь хар”, “Сайныг дагавал сарны гэрэл, мууг дагавал могойн хорлол”, “Хүн болох багаасаа хүлэг болох унаганаасаа”, “Санаа сайтын заяа сайн” гэх мэтээр олон үеийн туршид сургасаар иржээ. Хүмүүжилгүй хүн сахилга, хариуцлагатай байдаггүй тул даалгасан үүрэг биелүүлэх ёс суртахуун, сэтгэл зүйн бэлтгэлгүй, ам ажил хоёр нь байнга зөрж, бусдын итгэл найдварыг хүлээж чаддаггүй. Иймээс хүний сахилга, хариуцлагын анхдагч хэмжүүр нь хүмүүжил, төлөвшил юм. Хүмүүжил нь нийгэм, гэр бүл, хамт олон, хүрээлэн буй орчны хүрээнд, олон хүчин зүйлийн нөлөөн дор төлөвшдөг, хүний ухамсар, үйл ажиллагаагаар илэрч байдаг маш нарийн зүйл юм.

Хүн төрөлхтөн хойч үеийнхээ сайн сайхны төлөө байнга санаа тавьж, эд баялаг хураан өвлүүлэхээс гадна оюуны аугаа их баялаг хүнлэг энэрэнгүй, хүмүүжил төлөвшил сайтай байлгахыг зорьсоор иржээ. Хүмүүжил нь нэгэнт нийгэм дотор төлөвшил сайтай байлгахыг зорьсоор иржээ. Хүмүүжил нь нэгэнт нийгэм дотор төлөвшин төгөлдөрждөг үзэгдлийн хувьд эртнээс түүнийг эрхлэх байгууллага байсаар байв. 1990 он хүртэл Монгол Улсын Хилийн цэргийн хэмжээнд гэхэд л улс төрийн байгууллага, цэрэг олон түмний байгууллагууд (ХЗЭ, АХШГ, пост, нэр төрийн шүүхүүд, эмэгтэйчүүдийн зөвлөл, халагдах дайчдын зөвлөл) ажиллан, командлал, захирагч, дарга нарын шийдвэрийг биелүүлэхэд хамт олны хүчийг дайчилж, тэднийг хүмүүжүүлэхэд ажлаа чиглүүлэн зохих үр дүнд хүрч байсныг үгүйсгэх аргагүй юм.

Цэргийн доторх хүмүүжлийн ажлыг түүнийг удирдаж зохион байгуулахаар бэлтгэгдсэн мэргэжилтнүүд гардан зохион байгуулж байлаа. Хүмүүжлийн ажлын бүхэл бүтэн систем бүрэлдэн тогтож, хэлбэр, эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд өөрийн гэсэн тодорхой байр суурийг эзэлж байлаа.

1990 оноос ЗХУ (ОХУ)-д цэргийн улс төрийн сургуулиудыг татан буулгасан нь манайд ч нөлөөлжээ. Ардчилсан хувьсгал хүмүүсийн оюун санааг төдийгүй нийгэм төрийн байгууламж, системийг өөрчилсөн тул өнгөрсөн нийгэмд залуучуудыг Марксист-Ленинист сургаалаар коммунист болгон хүмүүжүүлэх зорилготой систем үгүй болж, өнөөг хүртэл баримжаа тогтоогүй ба хоосон орон зай бий боллоо. Энэ орон зайг элдэв янзын шашны урсгалууд, эх оронгүйжүүлэх, үгүйсгэх, устгах, өнгөрсөн болон ахмад үетэйгээ сөргөлдөх, талцах, намчирхах, нутгархах, ямар ч хамаагүй аргаар баяжих, хөлжих гэсэн үзлүүд чөлөөтэй эзэлж, гаднаас орж ирж байгаа видео -теле урсгал, залуучуудад алан хядах тонон дээрэмдэх, хүчирхийлэх, садар самуунд оролцох, мансуурах ажиллагааг сурталчилан сургаж байна.

Иймд үүнийг хэрхэн гэтлэн давах нь үндэстний, бүр улс үндсээ аврах асуудал болон тавигдах ёстой болов уу? Энэ орон зайг юуны урьд залуучуудыг эх оронч үзлээр хүмүүжүүлэх программ боловсруулж, эзэлмээр байна. Манай улстай тун адил байдалд байгаа Орос улс ч, коммунист системтэй Хятад улс ч өнгөрсөн үеийнхээ түүхэнд суурилсан эх оронч үзлийг төлөвшүүлэхэд тун их анхаарч, тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн, зохих үр дүнд хүрсээр байна.

Орчин үед “Монгол Улсын иргэдийн эх оронч хүмүүжлийн” төрийн программ үгүйлэгдэж байна. Энэ нь өмнөх үеийнхний ёс суртахууны шилдэг уламжлалыг үргэлжлүүлэх зайлшгүй шаардлагатай, хойшлуулшгүй авах ёстой арга хэмжээ юм.

Эдийн засгийн эмх замбараагүй байдал, нийгмийн ялгарал, оюуны үнэт зүйлийг тоохоо больсон зэрэг нь нийгмийн болон оршин суугчдын насны бүлгүүдийн ихэнхийг нь нийгмийн ухамсарт сөргөөр нөлөөлж, эх оронч үзлийг төлөвшүүлдэг чухал хүчин зүйлүүд болох Монголын урлаг соёл, боловсролын хүмүүжлийн нөлөө ихээхэн буурлаа.

Нийгмийн ухамсарт сэтгэл амирлангуй байдал, ихэмсэг, түрэмгий байдал, хувиа хичээсэн бэртэгчин үзэл, ширүүн догшин харьцаа, бусдыг үл хүндэтгэн үл тоох явдал, биеэ тоох үзэгдэл ихээхэн газар авчээ. Энэ нь цэргийн болон төрийн албаны нэр хүнд унаж байгаагаар илэрч байна. Иймээс төрийн түвшинд нийгмийг бат тогтвортой байлгах, төр улсыг бэхжүүлэх үндэс болсон эх оронч хүмүүжлийн системийн тулгамдсан хурц асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай боллоо. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд:

-иргэд, цэргийн албан хаагчдын эх оронч хүмүүжлийн шинж, үр ашигтай систем тогтоох;

-нийгмийн хамгийн чухал үнэт зүйл, нийгмийн оюун ухаан, ёс суртахууны нэгдэл нягтралын болон Монгол Улсын төрт ёсыг бэхжүүлэх үндэс болсон эх оронч үзлийг хөгжүүлэх, дахин сэргээх жинхэнэ замд нь оруулах шаардлага тавигдаж байна.

Хилийн цэргийн хэмжээнд эх оронч үзлийг төлөвшүүлэх төлөвлөгөө боловсруулж болох юм. Сайтар боловсруулсан төлөвлөгөө ч удирдлага, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээний үр дүнд хэрэгждэг болохоор амжилт нь түүнийг хэрэгжүүлэх нарийн механизм, сонирхогч талуудын үйл ажиллагааны нягт хамтын ажиллагаанаас хамаарна.

Хүнийг хүмүүжүүлэх болон мэдээлэл, соёл амралтын ажлын хүч, хэрэгслийг иж бүрнээр нь ашиглан, цэргийн хамт олон ба хилчдийн сэтгэл зүйн онцлогийг харгалзан, хил хамгаалалтын бүхий л үйл ажиллагааг ёс суртахуун, сэтгэл зүйн талаар чанартай хангахын тулд мэдээлэл сэтгэл зүйн сөрөг нөлөөнд эсрэг үйлчлэл үзүүлэх зайлшгүй шаардлагатай боллоо. Ашиглах нөөц ч их байна.

Цэргийн албан хаагчдын ертөнцийг үзэх үзлийн цар хүрээг өргөтгөх, нийгэм, улс төрийн бэлтгэлийн чанарыг ахиулж, тэдний нийгмийн идэвхийг дээшлүүлэх нь чухал болж байна.

Сургалт, хүмүүжлийн ажилд ялгавартай хандаж чадахгүй байгаагаас хүмүүсийн мэдлэг, чадвар шаардлага хангахгүй байна.

Цэрэгт ирэгсдийн боловсрол муугаас сургалт зохих хэмжээнд явагдах бололцоогүй байна. Үнэндээ боловсролгүй хүн хангалттай сурч чадахгүй. Сургууль төгссөн офицеруудын нилээд нь томилсон газарт очихгүй байна. Тэдний бэлтгэлийн түвшин ч хангалтгүй. Цэргийн ч биш, энгийн ч биш, эрх зүй ч биш, хилийн албаны ажилтан ч биш эрлийз, эрх биш офицер цол зүүсэн тэмдгээрээ ялгарч байна.

Цэргийн албан хаагчдыг сургаж, хүмүүжүүлэх зайлшгүй шаардлагын үүднээс Хилийн цэргийн сургуульд суралцагсдын мэргэжлийг сурган хүмүүжүүлэгч, сэтгэл судлаач, социологич-хилийн албаны ажилтан болгон өөрчилж, эх оронч үзлээр хүмүүжүүлж, гаргах шаардлагатай боллоо.

Хилчдийн хүмүүжилд нөлөөгөө үзүүлсээр ирсэн өөрийн гэсэн хэвлэл, мэдээлэл үгүйлэгдэж байна. Шар хэвлэл, бие биенээ талцаж гүтгэсэн өдөр тутмын сонингууд эерэгээсээ сөрөг мэдээлэл өгч, хүмүүсийг төөрөлдүүлж, эргэлзэлд оруулахаас хэтрэхгүй байна.

Иймд “Эх орны манаа” сонинг сэргээн гаргаж, бодлогоо хүргэж, хүмүүсийн дуу хоолойг сонсдог индэр болгох цаг боллоо.

Хилийн музейг улсын статустай болгож, дахин сэргээх, ангиудын алдрын танхимыг музей болгон өргөтгөх нь зүйтэй байна.

Хил, хилчдийн талаар уран бүтээл туурвих явдлыг системтэй болгон хөгжүүлэн дэмжиж, зохиолчдын цэрэг уран сайхны студи, теле болон радио студи, эх оронч дууны төв байгуулж, төрөл бүрийн уралдаан зарлан, цагийн албан аясыг даах, залуучуудын хүмүүжилд эерэгээр нөлөөлөхүйц шилдэг уран бүтээлүүд туурвих шаардлагатай болжээ.

Хилийн цэргийн дуу бүжгийн чуулгыг бүх талаар додомдон, хилчид төдийгүй Монгол түмэн шүтэн биширч, хүсч хүлээдэг уран бүтээлийн ариун сүм болтол нь хөгжүүлмээр байна. Хилийн цэрэг, хилчдийн эх оронч, дайчин уламжлалаар хүмүүжүүлэх эх булаг нь түүх юм.

Түүхээ мэдэхгүй хүнийг цөлд хаягдсан сармагчинтай зүйрлэдэг нь гүнзгий утга, агуулга, сургамжтай билээ. Өвөг дээдсийн алтан сургаал, Монгол Улсын хилийн төлөө ахмад үеийнхний зүтгэл, тэмцлийн түүх, уламжлалыг дэс дараатай судлах нь хөрөнгө хүч зарахгүйгээр бие бүрэлдэхүүнийг сургаж, хүмүүжүүлэх чухал хэрэгсэл билээ.

Дэлхий дахиныг хамарсан их нь багаа уусгах бодлогын эсрэг Орос, Хятадаас авахуулаад дэлхийн ихэнх орнууд түүхээ судлах ажил, эх оронч үзлийг сэргүүлэн тавьж байгааг ч анхаарууштай байна.

Монголын хилчдэд хил болон хамгаалалтын түүхээ судлах эхний боломж бүрдсэн гэж үзэж байна. Цэргийн албан хаагчдын хурал бараг хийгдэхээ больж, хийгдсэн ч захиргааны давуу талын илэрхийлэл болоод өнгөрч байна. Ялангуяа офицеруудын хурлыг нилээд ардчилсан, тэдний эрх ашгийг хамгаалдаг, үйл ажиллагаатай байгууллага болгон эрх хэмжээг нь өргөтгөх нь зүйтэй байна.

Энэ нь иргэний хяналтыг бүрдүүлэх, хүмүүст ололт, дутагдлаа цэгнэх, санал бодлоо чөлөөтэй солилцох боломжийг бүрдүүлэх болно. ОХУ болон бусад орнуудад ч иймэрхүү байдлаар ажиллаж байна. Офицер, цэргийн албан хаагчдын хурал, цэргийн алба, үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлж, хүмүүст итгэл, үнэмшлийг бий болгодог сайн талтай ажээ.

Хилийн цэрэг нийгмийн захиалгаар төрийн чухал үүргийг гүйцэтгэгч субъектийн хувьд Монголын нийгмийн нэг хэсэг болохоос тусгаарлагдсан организм бус, хил хамгаалах байгууллага, хилчдийн ажил үйлсийн талаарх эерэг сурталчилгаа тун бага байгаа нь нийгмийн сэтгэл зүйд муугаар нөлөөлж байна.

Иймд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр аль болохоор үнэн зөв мэдээлэл дамжуулж, алба нь үйл ажиллагаагаа төр засаг, ард түмэнд байгаагаар нь ойлгуулах нь чухал боллоо. Монголын нийгмийн байгууламж өөрчлөгдөхийн хирээр хүмүүсийн ухамсар, иргэдийн хүмүүжил, ёс суртахуун өөрчлөгджээ.

Нийгмийн хөгжил, хөдөлгөөнтэй хөл нийлүүлэхийн тулд шинэ зорилгыг хуучин арга, арга зүйгээр шийдвэрлэх бололцоогүй юм. Гэвч

ХИЛ СУДЛАЛ

уламжлагдан ирсэн, арга хэрэгслийг боловсронгуй болгон ашиглах нь жам ёсны асуудал болно.

Хүн төрөлхтний хуримтлуулсан аугаа их баялаг, ажлын арга туршлагыг хэн бүтээлчээр ашиглана тэр амжилтанд хүрэх нь мэдээж юм.

Аль ч орны цэргийн сургалтанд шаардлагатай бүхэнд сургахад дарга, захирагч нарын хувийн үлгэр дууриал, хууль дүрмээс ч илүү гэдгийг нотолжээ. Захирагдагсад нь даргынхаа санаатай, санамсаргүй үйлдлийг дуурайх зөн билэгтэй ажээ. Удирдагч хүн захирагдагсдынхаа толь нь учраас алдах эрхгүй юм. Иймээс захирагдагсадаа “намайг дууриа” зарчмаар хүмүүжүүлдгийн мөн чанар энэ ажгуу.

Нэгэнт нэр хүндээ алдсан удирдагч хүн хамт олныг удирдах ёс суртахууны эрхгүй болж олон нийтийн сэтгэл зүй түүнийг хүлээж авдаггүй зүй тогтолтой билээ.

Захирагч нь хууль дүрмээ гажуудуулж, архи дарс хэрэглэх, аливаа хээл хахуульд өртөх, завхайран самуурдаг тэр газар захирагдагсад нь түүнийг давтах сэтгэл зүйн бэлтгэлтэй болсон байдаг байна.

Бие бүрэлдэхүүн улсын хил хамгаалах хуулийн үүргээ үндсэндээ биелүүлж байна. Бие бүрэлдэхүүнийг Хилийн цэрэгт алба хааж байгаагаараа бахархдаг болгох хэрэгтэй байна. Үүний тулд төр, засгийн зүгээс их зүйл хийх шаардлага гарч байна.

Улсынхаа төлөө өөрийн хүч чадал, бололцоогоо харамгүй дайчлан ажиллаж, ажилдаа амжилт гаргаж байгаа хүмүүст төр хайр хишгээ харамгүй хүртээх ёстой.

Яагаад гэвэл иргэн, төрийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлээд байхад төр үнэлж цэгнэхгүй байж болохгүй. Өнөөдөр хилээс бусад бүх салбарынхан “Гавъяат” цолтой бөгөөд хүртсээр л байна. Гэтэл ажлын хүндийг хийгээд мартагдагсад нь хилчид байж болохгүй биз э!

Эх орныхоо төлөө амиа өргөсөн хүмүүс ч мартагдаж, хохироод л өнгөрч байна. Хилийн цэргийн офицер, ахлагч нарын эхнэр, хүүхэд ажилгүй, өөрийн гэсэн орон сууцгүй, боловсролоо ахиулах бололцоо муу, ирээдүйдээ итгэх итгэл бага байгаа нь залуучуудыг аль болохоор хилээс дайжихад хүргэж байна.

“Цэргийн албан хаагчид, тэдний гэр бүлийн талаар” хууль гаргах шаардлагатай боллоо. Орон нутгийн иргэд, байгууллагын хүч туслалцаа жигд биш байгаа нь алба, албан хаагчдад муугаар нөлөөлж байна.

Хил хамгаалалт нь ганцхан байгууллага, зөвхөн хилчдийн үүрэг бус Монголын иргэд, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны үр дүнд бэхжиж байх ёстойг бодолцож, иргэний ардчилсан нийгмийг зөв төлөвшүүлэхийн тулд төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах шаардлага амьдралаас урган гарч ирлээ.

Өнөөдөр Г.Дагважамц тэргүүлдэг “Монголын хил судлалын үндэсний нийгэмлэг”, “Хил судлал” сэтгүүл гарган хилчид, ард иргэдийг зохих мэдээллээр хангаж байгаа нь олзуурхан дэмжүүштэй ажил юм.

**ХЦУГ-ын хилийн түүх судлалын
секторын эрхлэгч, магистр, хурандаа
Ч.Алтангэрэл**